



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/220

Мандалговь

“Эс Жи Эм” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/185 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Адаацаг сумын сургуулийн сантехникийн засварын ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Эс Жи Эм” ХХК-тай 55,033,281 (тавин таван сая гучин гурван мянга хоёр зуун наян нэг) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Адаацаг сумын сургуулийн сантехникийн засварын ажил” нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Эс Жи Эм” ХХК-ийн захирал (С.Лхагва-Оргил)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060060